

**“НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ УЛААНБААТАР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,  
МЕНЕЖМЕНТ ҮЦК” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

---

2023 оны 3 сарын 13-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

“Нийслэлийн өмчит Улаанбаатар Хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хорооны хурлын тэмдэглэл:

**ХУРЛААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ :**

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн Болодын Мөнхдөлийн өргөдөлтэй танилцах
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдэд тавигдах шаардлагыг батлах, сонгон шалгаруулалтыг зарлах тухай.

**ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 1 :**

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн Б.Мөнхдөлийн өргөдөлтэй танилцах**

**Гишүүн Ж.Сандагсүрэн :**

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн Б.Мөнхдөл нь өөрийн хүсэлтээр тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээс гарах өргөдлөө өгсөн. Тиймээс Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн дээр нээлттэй сонгон шалгаруулалтыг зохих хууль, компанийн дүрэмд нийцүүлэн явуулах хүсэлтэй байна.

**ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ ГИШҮҮДИЙН САНАЛ:**

**Гишүүн Ж.Сандагсүрэн:**

Саналыг дэмжиж байна.

**Гишүүн: Б.Үүрцайхбаатар**

Саналыг дэмжиж байна.

**ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

**Гишүүн Ж.Сандагсүрэн**

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн Б.Мөнхдөл нь өөрийн хүсэлтээр тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээс гарах хүсэлтээ өгсөн тул сонгон шалгаруулалтыг зарлах нь зүйтэй гэж нэр дэвшүүлэх хорооноос шийдлээ.

**ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 2 :**

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдэд тавигдах шаардлагыг батлах, сонгон шалгаруулалтыг зарлах тухай**

## **Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Энхтөр :**

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос батлагдсан Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам, Компанийн дүрэмд заасан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдэд тавигдах шаардлагыг үндэслэн гаргаж танилцуулав.

Холбогдох хууль болон дүрэм, журмын дагуу дараах тавигдах шаардлагыг тусгалаа.

1. Дээд боловсролтой байх
2. Компанитай нэгдмэл сонирхолтой болон компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын /хувьцаа эзэмшигчид, хувьцааны багцыг эзэмшигч, хамтран ажиллагсад гэх мэт/ ашиг сонирхлыг төлөөлдөггүй байхаас гадна бизнесийн аливаа холбоогүй байх
3. Тодорхой ажил, албан тушаал эрхлэх, эсвэл үйл ажиллагаа явуулах эрхийг нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр түдгэлзүүлээгүй, хасаагүй, ял шийтгэл хүлээгээгүй байх
4. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байхад ашиг сонирхол үүсгэхгүй байх.
5. Санхүүгийн зах зээл дээр гурваас (3) доошгүй жил ажилласан туршлагатай, энэ чиглэлээр мэргэшсэн
6. Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд болон банк, даатгал, бусад санхүүгийн компанид зөрчлийн улмаас тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үед нь удирдлагад нь ажиллаж байсан бөгөөд зөвшөөрөл хүчингүй болсноос хойш гурван (3) жил өнгөрсөн байх
7. Санхүү, үнэт цаасны зах зээлд гаргасан зөрчлийн улмаас захиргааны хариуцлага хүлээнээс хойш нэг (1) жил өнгөрсөн байх
8. Тухайн компани болон түүний холбогдох этгээдэд ажил албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд эрхэлж байгаагүй
9. Бизнесийн харилцаатай компанийн толгой эсхүл охин, хараат компанийн ажилтан, албан тушаалтан биш байх
10. Хугацаа хэтэрсэн болон шүүхийн шийдвэртэй өр төлбөргүй байх
11. Компанийн засаглалын сургалтад хамрагдсан байх

## **Гишүүн Ж.Сандагсүрэн :**

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдэд тавигдах дээрх шаардлагыг үндэслэн сонгон шалгаруулалтын зарыг 2023 оны 3 дугаар сарын 14-ны өдрөөс Компанийн веб сайт, социал суваг болон өдөр тутмын сонинд байршуулан 14 хоногийн хугацаатай материалыг хүлээн авч, оролцогчдын материалыг Нэр дэвшүүлэх хороонд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Энхтөрд даалгах саналтай байна.

**ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ ГИШҮҮДИЙН САНАЛ:**

**Гишүүн Ж.Сандагсүрэн :**

Саналыг дэмжиж байна.

**Гишүүн Б.Үүрцайхбаатар**

Саналыг дэмжиж байна.

**ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

**Гишүүн Ж.Сандагсүрэн :**

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг 2023 оны 3 дугаар сарын 14-ний өдрөөс Компанийн веб сайт, социал суваг болон өдөр тутмын сонинд байршуулж оролцогчдын материалыг 2023 оны 3 дугаар сарын 28-ны өдрийг хүртэл хүлээн авч, материалаа ирүүлсэн оролцогчдын материалыг Нэр дэвшүүлэх хороонд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Энхтөрд үүрэг болгоё.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ  
ГИШҮҮД :**

Ж.САНДАГСҮРЭН



Б.ҮҮРЦАЙХБААТАР



**ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН :**

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА**

Д.ЭНХТӨР

